

ДУНДАД УЛСЫН МОНГОЛ СОНИН, СЭТГҮҮЛИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ ХИЙГЭЭД ОНЦЛОГ

Оюун*

* Өвөр Монголын Их Сургуулийн сонин мэдээ, хэвлэлийн ажилтны салбарын эрхлэгч, профессор

Түлхүүр үг: сонин, сэтгүүл, хөгжлийн ерөнхий байдал, нийтлэлийн агуулга

Товч агуулга: найдвартай бичиг материалын баримт бүхий хамгийн анхны монгол сонин “Дорнод хязгаарын амьдрал” 1895 онд Оросын Чита хотод хэвлэгдэн, монгол сонин, сэтгүүлийн үйлсийн хөшгийг ярсан юм. 1905 онд Харчин баруун хошууны засаг жүн ван Гүнсээноров хошуундаа “Гаригийн албан сэтгүүл” ба “Нялх сэтгүүл”-ийг эрхэлснээс эхлэн 1949 оны 9-р сар болтолх бараг хагас зууны турш Дундад улсын хил хязгаар дотор нийт 131 монгол сонин, сэтгүүл хэвлэгджээ.

Гэтэл харамсалтай нь эдгээр сонин, сэтгүүлүүдээс бидний үед өвлөгдөн хадгалагдаж үлдсэн нь зөвхөн 87 бөгөөд бусад нь цөм ийм сонин, сэтгүүл хэвлэгдэж байсан гэсэн мэдээ төдийхөн юм. Дундад улсын монгол сонин, сэтгүүлүүд засгийн газрын хууль зарлиг, хөтөлбөр ба шийдвэрийг уламжлан дэлгэрүүлэх, эл зүйлийн улс төрийн хүчний ашиг тусыг хамгаалахад яриа хэлэлцээр зохиох, жич монголчуудад шинэ мэдлэг уламжлан, тэднийг соён гэгээрүүлэхэд зохих үйлдэл

үзүүлсэн юм. Тэрчлэн сонин, сэтгүүл нь нийгмийн амьдралын тусгал болсны хувьд тухайн цаг үеийн чухал хэрэг учруудыг зохин хэмжээгээр тусгаж, бидний үед үлдэж ирсэн монгол сонин, сэтгүүлийн уг материал нь хэвлэл мэдээлэл, аж ахуй, улс төр, түүх соёл, зан үйл зэрэг шинжилгээний судалгаанд сурвалж бичгийн үнэ өртөгтэй юм.

Нэг. Монгол сонин, сэтгүүлийн хөгжлийн ерөнхий байдал

Дундад улсын монгол сонин, сэтгүүл дотроос “Гаригийн албан сэтгүүл”, “Нялх сэтгүүл”, “Улаан бар”, “Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал”, “Ирээдүйн Монгол”, “Язгууртан улс”, “Манхын хонх”, “Шинэ Монгол”, “Дахин мандсан Монголын чимээ”, “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” зэргийн цөөхөн хэдэн сонин, сэтгүүлийг монголчууд буюу монголчуудын хурал бүлгэмүүд эрхэлж байсныг гаргавал бусад нь цөм Дундад улсын засгийн газар, “Манж улс” ба “Монголын хязгаарын засаг” буюу Орос, Японы төлөөний хүмүүс, ардаас эрхэлсэн хурал нийгэмлэгүүдээс засгийн газрын дэмжлэгтэй гаргаж байсан юм.

Одоогоор бидний эзэмшиж байгаа материалд суурилбал, 1895 оноос 1949 оны 9-р сар болтол Дундад улсын хил дотор нийт 131 монгол сонин, сэтгүүл гарч байжээ. Үүнд сонин 56 (энэ нь бүх сонин, сэтгүүлийн 42,7%-ийг эзэлнэ), сэтгүүл 75 (бүх сонин, сэтгүүлийн 57,3%-ийг эзэлнэ) байв. Эдгээр сонин, сэтгүүлийг хэвлэл эрхэлсэн цагаар нь бүртгэвэл, Чин улсын сүүлчийн үед (1895-1911 он) 6 сонин, сэтгүүл (4,6%-ийг эзэлнэ) хэвлэгдэж (1), Иргэн улсын Бээжингийн засгийн газрын үед (1912-1927 он) 17 сонин, сэтгүүл (12,9%-ийг эзэлнэ) дармалагдаж (2), Иргэн улсын Нанжингийн засгийн газрын үед (1928-1949 он) 99 сонин, сэтгүүл (75,6%-ийг эзэлнэ) хэвлэгдэж байснаас (3) гадна хэвлэгдсэн цаг хугацаа нь тодорхойгүй сонин, сэтгүүл нийт 9 (6,9%-ийг эзэлнэ) буй ажээ (4).

Хэвлэл үргэлжилсэн цагаар бүртгэвэл, хагас жилийн дотор гарч байсан сонин, сэтгүүл 31 (23,7%), нэг жилийн дотор гарч байсан сонин, сэтгүүл 25 (19,1%), 3 жилийн дотор гарч байсан сонин, сэтгүүл 29 (22,15%), 5 жилийн дотор гарч байсан сонин, сэтгүүл 7 (5,3%), 10 жилийн дотор гарч байсан сонин, сэтгүүл 7 (5,3%), 15 жилээс дээш хугацаагаар гарч байсан сонин, сэтгүүл 3 (2,3%), гарч байсан цаг хугацаа тодорхойгүй нь 29 (22,15%) буй (5).

Эдгээр сонин, сэтгүүлийг хэвлэгдэж байсан газар орноор бүртгэвэл, Бээжинд 8 (6,1%), Нанжинд 13 (9,9%), Чүнчинд 2 (1,5%), Хөххотод 11 (8,4%), Чуулалт хаалганд 13 (9,9%), зүүн хойт гурван мужид 23, түүний дотор Чанчунд 16 буй (17,6%), Өвөр Монголын зүүн хэсэгт 31, түүний дотор Улаан хотод 14 буй (23,7%), Өвөр Монголын баруун хэсэгт 11 (8,4%), Шинжанд 7 (5,3%), Шаньсид 3 (2,3%), Их хүрээнд

(одоогийн Улаанбаатар) 3 (2,3%), Японд 3 (2,3%) сонин, сэтгүүл тус тус хэвлэгдэж байснаас гадна гарч байсан газар орон нь тодорхойгүй сонин, сэтгүүл 3 (2,3%) буй (6).

Монгол сонин, сэтгүүлийг хэрэглэсэн үсэг бичгээр бүртгэвэл, хятад, монгол хавсаргасан хэвлэл нийт 63 (48,1%), монгол хэвлэл нийт 56 (42,7%), бусад зүйл 12 (9,2%) буй. Бар мэргэжлээр бүртгэвэл, чулуун барын хэвлэл 41 (31,3%), хорголжин барын хэвлэл 35 (26,7%), тосон дармал 34 (26%), бар мэргэжил тодорхойгүй сонин, сэтгүүл 21 (16%) буй (7).

Дээрх тоо баримтаас дараах хэдэн талын онцлогийг ойлгож болно:

1. Дундад улсын монгол сонин, сэтгүүлүүдийг эл зүйлийн улс төрийн хүчин Монгол орныг булаалдах, Монголын асуудлыг ярилцах суртал ухуулгын багажийн хувиар гаргаж байсан учраас албанаас эрхэлсэн болон албаны дэмжлэгтэй хурал бүлгэмийн эрхэлсэн сонин, сэтгүүл гол байрыг эзэлж, харин монголчуудын өөрсдийн эрхэлсэн сонин, сэтгүүл харьцангуй цөөхөн тоог эзэлж буй. XIX зууны сүүлчээс XX зууны эхний хагаст монголчууд улс төрийн талаар бие даасан эрхгүй, аж ахуйгаар хоцронгүй, ядуу байсан болохоор монголчуудын өөрсдөө эрхэлсэн сонин, сэтгүүлүүд тоотой хэдхэн байсан бөгөөд хэвлэл үргэлжилсэн цаг хугацаа ч охорхон байсан юм.

2. Дундад улсын монгол сонин, сэтгүүлийн дотор сэтгүүл нь сониноосоо харьцангуй олон байгаа юм. Тэрчлэн 56 төрлийн сонин доторх 30-ийг нь 1945 оноос хойш эрхэлсэн байдаг. Дундад улсын Монгол орны нутаг дэвсгэр өргөн уудам, хүн амын суурьшил тархай бутархай бөгөөд тухайн үеийн Монгол орны зам

харилцаа, шуудан холбооны ажлыг дотор газартай харьцуулбал маш хоцронгуй, буйд бөглүү байсан юм. Иймэрхүү байдалд номын хэлбэрээр дэвтэрлэж үдсэн сэтгүүл нь нүүр хуудсаар олон, үелэх хугацаа харьцангуй урт байсан учраас сониныг бодвол авч явахад дөхөм, агуулгын багтаамж их байх нь буйд бөглүү газар орны уншигчдын гарт хүрэхэд нэлээд өдөр хоног хэрэгсдэг байдалтай нийцэж байдаг юм.

3. Дундад улсын монгол сонин, сэтгүүл олшрон хөгжиж иржээ. Чин улсын сүүлчийн үед дунджаар жил бүр 0,35 дармал гарч, Иргэн улсын Бээжингийн засгийн газрын үед дунджаар жил бүр 1,06 монгол сонин, сэтгүүл хэвлэгдэж, Иргэн улсын Нанжингийн засгийн газрын үед дунджаар жил бүр 4,5 сонин, сэтгүүл гарч байсан бөгөөд энэ нь Дундад улсын бүх монгол сонин, сэтгүүлийн 75,6%-ийг эзэлж байв. Иймэрхүү үзэгдэл бий болсны шалтгаан бол тус цаг хугацаанд Нанжингийн засгийн газар, "Манж улс" (8) ба "Монголын хязгаарын засаг" (9) жич Зүүн Монголын түр цагийн засгийн ордон, Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөний холбоот хурал, Өвөр Монголын өөртөө засах засгийн ордон зэрэг байгуулагдаж, эдгээр засгийн газрууд нь тус тусын засаг явуулах бодлогоо уламжлах хэрэгцээтэй байсны хамт Японыг эсэргүүцэх дайн жич дотоодын дайн дэгдсэн цаг үе болохоор ард олноо дайчлан уриалах буюу тэднийг татан авах шаардлагатай байснаас болсон юм.

4. Дундад улсын Монголын нийгэм бол урваан хөрвөөнтэй байсан бөгөөд дайн дажин ихтэй байсан болохоор монгол сонин, сэтгүүлүүд цаг үеийн үймээн дэвжээнээс болоод цөм урт хугацаанд үргэлжлэн гарч чадаагүй

юм. Тэрчлэн зарим сонин, сэтгүүл нь нэг буюу хэдхэн дугаар гараад тасардаг байв. Бүртгэлээс үзвэл, 10 жилийн дотор гарч байсан сонин, сэтгүүл 7, 15 жилийн дотор гарч байсан сонин, сэтгүүл 3 буй. Тэрчлэн энэ 10 төрлийн сонин, сэтгүүлийн олонх нь нам засгийн талаас эрхэлж байсан албан хэвлэл болох юм.

5. Дундад улсын монгол сонин, сэтгүүлийн хэвлэгдэж байсан газар орон нэлээд өргөн байсан боловч, Бээжин, Нанжин, Чанчун, Хөххот, Чуулалт хаалга, Улаан хотод харьцангуй олон гарч байсан юм. Учир нь эдгээр газар орон бол тухайн үеийн Чин улсын засгийн газар, Бээжингийн засгийн газар, Нанжингийн засгийн газар, "Манж улс", "Монголын хязгаарын засаг", Өвөр Монголын өөртөө засах засгийн ордны төв орон байсан юм. Иймээс тухайн үеийн Дундад улсын улс төр, аж ахуй, соёлын төв орон болсон эдгээр хотод соёлын үзэгдэл болсон сонин, сэтгүүлийн үйлс энд өрнөн хөгжсөн нь хэвийн үзэгдэл байв.

6. Монгол сонин, сэтгүүлийн дотор хятад монгол хавсаргасан хэвлэл бараг бүх сонин, сэтгүүлийн хагасыг эзэлж буй. Үүнд оросууд болон япончуудын эрхэлсэн сонин, сэтгүүл жич "Манж улс" ба "Монголын хязгаарын засаг"-ийн харьяанд байсан зарим сонин, сэтгүүлүүд цул монгол хэвлэл байсныг гаргавал, Дундад улсын албанаас эрхэлсэн буюу албаны дэмжлэгтэй хурал нийгэмлэгийн сонин, сэтгүүлүүдийн олонх нь цөм хятад монгол харьцуулсан хэвлэл юм. Энэ нь Дундад улсын засгийн газрын эзэмдэл буюу засгийн газрын цөөн тоот үндэстнийг Хятадад хайлуулах гэсэн төрийн бодлогын шаардлагаас болсон юм гэж ойлгож болно.

7. Монгол сонин, сэтгүүлүүд хорголжин бар, чулуун бар, тосон бар гэх гурван зүйлийн бар мэргэжлийг хэрэглэж байсан бөгөөд хэвлэл мэргэжлийн хувьд чулуун бар нь нэлээд түгээмэл хэрэглэгдэж байжээ. Гэтэл 1945 оноос хойш гарч байсан сонин, сэтгүүлүүдийн олонх нь дайны тухай ухуулах, намын хөтөлбөр ба бодлогыг уламжлах бачим яаралтай ухуулгын шаардлагаас болж үелэх хугацаагаар охор сонины хэлбэрээр гарч байсан бөгөөд өөрийн өртгөөр доор тосон дармалаар дармалагдаж байсан юм. Монгол хорголжин барын хэвлэл харьцангуй цөөн байсны учир бол тухайн цаг үед Дундад улсад монгол хорголжин бар үүдэгдээд удаагүй бөгөөд түгээмэлжиж амжаагүй байсантай холбоотой.

Хоёр. Дундад улсын монгол сонин, сэтгүүлийн агуулгын онцлог
Дундад улсын монгол сонин, сэтгүүлийг улс үндэстний доройтон мөхөх аюул түгшүүрт түүхэн ахуй байдалд эл зүйлийн улс төрийн хүчин Монгол орныг булаалдах, улс төрийн үзэлдээ ухуулах, өөрийн ашиг тусаа хамгаалах, Монголын нийгмийн асуудлыг ярилцах, монгол үндэстнээ мандуулах яриа хэлэлцээний багажийн хувиар эрхэлсэн болохоор улс төрийн өгүүллийн сонин, сэтгүүл бол Дундад улсын монгол сонин, сэтгүүлийн гол урсгал болно.

Асуудлыг дэлгэн нягтлахын төлөө нөлөө ихтэй төлөөлөгч чанартай сонин, сэтгүүлүүд эрхэлсэн үндсэн зорилтыг урдаар үзье:

Сонин, сэтгүүл	Үндсэн зорилт
"Нялх сэтгүүл"	Ардын мэдлийг нээн шинэ засгийг сурталчлах
"Монгол үгийн бодрол"	Монгол ардын ухаан мэдлийг "дэлгэрүүлэх", монголчуудыг "дотогш хандуулах"
"Монголын сонин бичиг"	Хаант Оросын "Алс дорнодын бодлого"-ыг идэвхжүүлэх
"Сонин бичиг"	"Хамт найралдах" үзэлтийг ухуулж, монголчуудыг "дотогш хандуулах"
"Ихэд нийтлэх монгол бичгийн сэтгүүл"	"Хамт найралдах" үзэлтийг ухуулж, монголчуудыг "дотогш хандуулах"
"Монгол ер үгийн сэтгүүл"	Монгол ардын ухаан мэдлийг нэвтрүүлж, "Таван угсаа хамтаар найралдах" үзэлтийг ухуулах
"Шинэ толь хэмээх бичиг"	Монголчуудыг "элдэв эрдэмд боловсруулж, яаравчлан хүчтэй чийрэг болгох"
"Шо Фан-гийн өдрийн сэтгүүл"	Засаг яамны хууль цаазыг ухуулж, Ар монголчуудыг илбэх буюу сүрдүүлж байгаад Иргэн улсад дагуулах
"Мүгдэний монгол сэтгүүл"	Японы "Манж, Монголын тухай бодлого"-ыг идэвхжүүлэх
"Монгол үсгийн нэгэн эргэлтийн хэвлэл"	Монголчуудын үндэстний ухамсрыг арилгаж, "улс гүрний үзэлт"-ийг буй болгох
"Дотоод Монголын ардын сэтгүүл"	Монгол ардын ашиг тусыг хамгаалах, төөрөгдсөнийг арилгах, эрх чөлөө, эрдэм соёлыг бадруулах
"Монгол, Төвдийн долоон өдрийн сэтгүүл"	Ардын гурван зорилтыг ухуулан монгол, төвд угсаатан гэдэг бол Дундадын үндэстэн гэдгийг таниулах

"Монгол, Төвдийн сарын сэтгүүл"	Засгийн газрын "Өршөөлт засаглал"-ыг ухуулж, монгол, төвд үндэстний улс гэрийн үзэлтийг буй болгох
"Монгол, Төвдийн 10 өдрийн сэтгүүл"	Ардын гурван зорилтыг ухуулан монгол, төвд угсаатан гэдэг бол Дундадын үндэстэн гэдгийг таниулах
"Монгол утгын 7 өдрийн дармал"	Ардын гурван зорилтыг сурталчлан засгийн яамны цааз зарлалыг тархаах
"Монголын 10 өдрийн дармал"	Улсын ардын намын зорилт, засгийн хэлхээ ба төв дундадын цааз зарлалыг Монгол газар дэлгэрүүлэх
"Жун Ян Бэн Бао"	Ардын гурван зорилтыг бадруулан засгийн газрын бодлогыг ухуулах
"Алаша хошууны дөхөм сэтгүүл"	Ардын гурван зорилтыг дэлгэрүүлэн төв засгийн хууль зарлигийг ухуулах
"Ард олны өдрийн сэтгүүл"	Ардын гурван зорилтыг ухуулан, Японыг эсэргүүцэхийг сурталчлах
"Монгол"	Унтарсан Монголоо дуудан сэрээж, эрх хүчит, өнө бат жаргалангийн хүрээлэнг байгуулах
"Ирээдүйн Монгол"	Ард угсаагийн санаа ухааныг төрүүлэн бүгдээр нэгдэж бүх Монголын төлөө чармайх
"Язгууртан улс"	Монголын асуудлыг ярилцах, монгол угсаагаа авран мандуулах
"Манхын хонх"	Монгол ардын эрдэм сургаалийг дэлгэрүүлэн, ухаан мэдлийг нээгдүүлэн утга соёлыг урагш дэвшүүлэх
"Шинэ Монгол"	Японы шинэ соёлыг монголд удирдан оруулж, Монголын эрдэм соёлыг хөгжүүлэн дэлгэрүүлэх
"Монгол хошуун дор тархаах 10 өдрийн дармал"	Таван угсааг нэгэн гэр болгож, хамт санаагаар харилцан туслалцан ихэд нийцлэхүй дор шаардан давшуулах
"Зах хязгаарын чимээ нэвтрүүлэх сэтгүүл"	Ардын гурван зорилтыг ухуулан, монгол ардыг Японыг эсэргүүцэх дайнд дайчлах
"Монгол утгын 7 өдрийн сэтгүүл"	Намын зорилтыг дэлгэрүүлэн, ардын засгийг ухуулан, монгол ардыг "дотогш хандуулах"
"Сүй Юань монгол үсгийн хагас сарын дармал"	Таван угсаа эрх тэгшийг ухуулан "Дундадын үндэстэн" гэдгийг сурталчлах, засаг бодлогыг хөгжүүлэх
"Хянган ерөнхий балгадын хураангуй дармал"	"Манж улс"-ын засгийн зарлалыг уламжлах, Хянган ерөнхий балгадын ажлыг жолоодох
"Монгол сэтгүүл"	Монгол ардыг ухамсруулан, үндэстнээ сэргээн мандуулах
"Хөх туг"	Монгол ардын ухаан мэдлийг нэмэгдүүлэх, улсын доторх засаг засалт хийгээд аж ахуйн байдлыг ойлгуулах
"Улаан бар"	Монгол угсаатны оюун билгийг нэмэгдүүлэн, монгол угсаагийн утга соёлыг боловсруулан хөгжөөх

"Засгийн ордны агуу чимээ"	"Монголын хязгаарын засаг"-ийн хууль зарлалыг уламжлах
"Монголын 7 өдрийн сэтгүүл"	Монголоо дахин мандуулах, "Зүүн Азийн хамт хөгжилдөх хүрээлэн"-г байгуулах
"Монгол соёлын тусгай дармал"	Монголчуудын төрөлх соёлыг хөгжүүлж, шинэ соёлыг шингээн авах
"Дахин мандсан Монголын чимээ"	Монгол соёлыг дэлгэрүүлэх, дахин мандсан Монголын хэрэгт тус болох
"Мандах Монгол"	Эх Монголын эрдэм соёлын хөгжилтөд хувь нэмэр үзүүлэх
"Дотоод Монголын гаригийн сэтгүүл"	Эв хамт намын эл зүйлийн төрийн бодлогыг ухуулах, бүх улсыг чөлөөлөхөд туслах
"Олон түмэн" (Вангийн сүм)	Олон түмний улс төр, аж ахуй, соёл боловсролын аливаа биеэ хөрвүүлэх тэмцлийг хөдөлгөн удирдах
"Дотоод Монгол"	Хянган мужийн засгийн ордны хууль зарлал ба хувьсгалын тухай ухуулах
"Эрх чөлөө"	Гоминданы хятадчилах үзлийг эсэргүүцэх, ардчилсан хувьсгалыг биелүүлэх
"Өвөр Монголын өдрийн сонин"	Ард түмний улс төрийн ухамсар ба соёлын хэр хэмжээг дээшлүүлэх
"Ардын зам"	Монгол үндэстний тусгаар тогтнол, эрх чөлөө ба хөгжилтийг тэмцэн олох
"Монгол ард"	Зөвлөлтийн улаан цэргийг магтах, Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг танилцуулах

Дээрх хүснэгтээс мэдэж болох нь, Дундад улсын монгол сонин, сэтгүүлүүдийн үндсэн зорилтыг ерөнхийдөө "монгол ардын ухаан мэдлийг нээгдүүлэх", "улс гүрний үзэлт"-ийг ухуулах, "хамт найралдах"-ыг ухуулах, "ардын гурван зорилтыг уламжлах", засгийн газрын "засаг засалт"-ыг уламжлах, "утга соёлоо хөгжүүлэх", "Монголоо мандуулах" (тусгаар тогтнол, эрх чөлөөг тэмцэн олох), "эв хамт ёсыг ухуулах", "Зүүн Азийн хамт хөгжилдөх хүрээлэн"-г байгуулах, Хаант Оросын "Алс дорнодын бодлого" ба Япон улсын "Манж, Монголын тухай бодлого"-ыг идэвхжүүлэх гэх хэдэн зүйлд төрөлжүүлж болно. Дундад улсын монгол сонин, сэтгүүлүүд нь дээрх

үндсэн зорилтын эргэн тойронд асуудлыг дэлгэн өгүүлж яриа хэлэлцээ зохиож байсан юм.

Дундад улсын монгол сонин, сэтгүүл нь улс төрийн өгүүллийн сонин, сэтгүүл болсны хувьд бусад сонин, сэтгүүлээс ялгагдах доорх хэдэн талын хэв намба буюу онцлогтой:

1. Шүүмж өгүүллийн онцлогтой. Монгол сонин, сэтгүүл нь эл зүйлийн улс төрийн хүчин Монгол орныг булаалдах, Монгол оронд явуулах засаг бодлогоо найдваржуулах, Монгол орон дахь арилжаа худалдааны ашиг тусаа хамгаалах, Монголын асуудлыг ярилцах ба Монголоо мандуулах зэргийн маш тодорхой зорилтоор эрхлэгдсэн байдаг. Иймээс энэ цаг үеийн монгол сонин, сэтгүүлүүд агуулгын

хувьд энэхүү зорилтоо биелүүлэхийн төлөө дээрх асуудлуудын тухай шүүмжлэн өгүүлэхийг чухал байранд тавьж, агуулга ба хэлбэрийн хувьд улс төрийн өгүүлэл шүүмжээр гол болгодог, энэ нь монгол сонин, сэтгүүлийг багтаасан Дундад улсын сонин мэдээллийн үйлсийн уламжлал буюу онцлог болж бүрэлдсэн байдаг.

2. Дундад улсын монгол сонин, сэтгүүлийг агуулгын хувьд үзвэл, хэдийгээр улс төрийн шүүмж өгүүллийг чухалчилдаг боловч сонин мэдээллийг гадуурчлахгүйгээр зохих хэмжээнээ хүндэтгэн үздэг. Тэрчлэн цөөн хэдэн сонин, сэтгүүлийн мэдээллийн хувийн жин харьцангуй их байх үзэгдэл ч буй. Гэвч энэ нь сонин, сэтгүүл эрхлэгчдийн үндсэн зорилт биш, харин уншигчдад мэдээ занги хангахаар дамжуулан түүнийг сонин, сэтгүүлийнхээ суртал ухуулгадаа үйлчлүүлсэн байдаг.

3. Дундад улсын монгол сонин, сэтгүүл улс төрийн өгүүллийн сонин, сэтгүүл болсны хувьд зар сурталчилгааг зүгээр нэг чухалчилдаггүй. Тус цаг үеийн монгол сонин, сэтгүүлийн цөөхөвтөр хэдэн нь хааяа хэдэн зар нийтэлдэг бөгөөд бусад олонх дээр нь зар сурталчилгаа бараг харагдахгүй байдаг. Учир нь улс төрийн өгүүллийн сонин, сэтгүүлийг бол эрхлэгчид нь өөрийнхөө үзэл санаа үзэлдээ ухуулах, яриа хэлэлцээ зохиох тодорхой зорилтоор гаргадаг болохоор цөм тус тусынхаа дармал эрхлэх үндсэн зорилттой байж гол хүчээ улс төрийн ухуулга дээр

тавиад ашиг орлогыг дэмий хөөцөлддөггүй юм.

4. Дундад улсын монгол сонин, сэтгүүл цөм улс төрийн тодорхой зорилтоор эрхлэгдсэн болохоор яриа хэлэлцээ зохиох, суртал ухуулгыг голчлон анхаараад уншигчдын дур сонирхол, хэрэгцээ шаардлага ба хүлээн авах чадварыг дэмий хамаардаггүй юм. Зарим сонин, сэтгүүлд хэдийгээр

уншигчдын дур сонирхол, хэрэгцээ ба хүлээн авах чадварыг зохих хэмжээгээр бодолхийлсон зүйл байх боловч (жишээлбэл, зохих хэмжээний мэдээлэл нийтлэх, дөхөм ойлгомжтой ёгт үлгэр, хошин шог зураг жич ухуулгын зургийг

«
*Монгол сонин, сэтгүүл нь Шүүмж
өгүүллийн онцлогтой. Эл зүйлийн улс
төрийн хүчин Монгол орныг
булаалдах, Монгол оронд явуулах засаг
бодлогоо найдваржуулах, Монгол орон
дахь арилжаа худалдааны ашиг тусаа
хамгаалах, Монголын асуудлыг
ярилцах ба Монголоо мандуулах
зэргийн маш тодорхой зорилтоор
эрхлэгдсэн байдаг.*
»

гаргах, сонин, сэтгүүлийн нүүр хуудсаа чимэх зэрэг) энэ нь суртал ухуулгаа нэн сайн хийхэд зориулагдсан байсан юм.

5. Дундад улсын монгол сонин, сэтгүүл нь улс төрийн өгүүллийн агуулга, зорилготой болсны хувьд, нэгд, эрхлэгчид нь өөрийн үзэл санаа буюу үзэлтээ уламжлах, монгол ардын ухаан мэдлийг нээх, үзэл санаагаа чөлөөлөхийг чухалчилдагаас ард иргэдийг соён гэгээрүүлэх, яриа хэлэлцээ зохиох буюу нөлөөлөх үйлдэлтэй байв. Хоёрт, улс төрийн өгүүллийн сонины суртал ухуулгыг өрнүүлэн яриа хэлэлцээ зохиох онцлог нь сүүлийн үеийн намын сонины намч чанарын онцлогийг бүрэлдүүлэхэд суурь тавьсан юм. Энэ бол Дундад улсын монгол сонин, сэтгүүлийг багтаасан Дундад улсын улс

төрийн өгүүллийн сонин, сэтгүүлийн хэвлэл мэдээллийн түүхэн дэх байр суурь болон хойшдын хэвлэл мэдээллийн үйлсэд үзүүлсэн нөлөө болно.

Тайлбар

1. Чин Улс (1636-1911 он): 1634 оны 4-р сард Зүрчидийн Тэнгэрийн Сэцэн хан Дундад улсын Мүгдэн хотонд Их Хуралдай хуралдуулав. Энэ хуралд Монголын Лигдэн хааны хөвгүүн Ээжэй тэргүүтэй Монголын 16 аймаг бүлгийн язгууртад жич Манж, Хятадын язгууртнууд оролцож, Тэнгэрийн Сэцэн ханыг "Богд Сэцэн хаан" хэмээн өргөмжилж, Улсын цолоо Дайчин улс хэмээв. Үүнийг түүхэн дээр Чин улс гэдэг. Энэ төр Дундад улсыг 1911 он болтол ноёрхсон юм.

2. Бээжингийн засгийн газар (1912-1927 он): 1911 оны 10-р сард Дундад улсад Цагаагчин гахай жилийн хувьсгал үүсч, Манж Чингийн төрийг татан буулгав. 1912 оны 1-р сарын 1-нд Дундад Иргэн Улс байгуулагдаж, мөн оны 3-р сард Юань Ши Кай Бээжинд Дундад Иргэн Улсын түр цагийн ерөнхийлөгч болов. Үүнийг Дундад Улсын түүхэнд Иргэн Улсын Бээжингийн засгийн газар гэдэг. Энэ засгийн газар Дундад улсыг 1927 он болтол ноёрхсон юм.

3. Иргэн Улсын Нанжингийн засгийн газар (1928-1949 он): 1927 онд Жан Жие Ши (Чан Кай Ши) "Иргэний засгийн газар" гэгчийг байгуулан Нанжинд нийслэлжээ. 1928 онд хоёр дахь удаа умарш дайлж, мөн оны 6-р сард Бээжин, Тяньжинг эзэлж, Бээжингийн засгийн газрыг татан буулгажээ. Нанжинд нийслэлсэн "Иргэний засгийн газар"-ыг Дундад Улсын түүхэнд Иргэн улсын Нанжингийн засгийн газар гэдэг. Энэ засгийн газар 1949 он болтол Дундад улсыг ноёрхсон юм.

4. 5. 6. 7. Тус тоо магад бол зохиогч Монгол сонин, сэтгүүлийг цуглуулан эмхэтгэж судлах явцдаа бүртгэж гаргасан тоо магад болно.

6. "Манж улс": 1932 оны 3-р сарын 1-нд Японы цэргийн талын тохируулгаар "Манж улс"-ын засгийн газар Чанчун хотод байгуулагдав. Улсын нутаг дэвсгэр нь Мүгдэн, Гэрэн, Хар мөрөн, Халуун гол зэрэг дөрвөн муж ба Жирэм, Зуу-Уд, Зост зэрэг гурван чуулган хийгээд Хөлөн буйрыг багтааж, Улсын тэргүүн Пү И-г "засаг баригч" хэмээж, оны цолыг "Ихдээ нийтлэгч" хэмээн тогтоожээ. 1934 оны 3-р сарын 9-нд "Манж улс" хаант байгууллыг хэрэгжүүлж Пү И хаан сууж, оны цолоо "Энх эрдэмт" хэмээв. Үүнийг Хятадын түүхэнд "Манж улс" хэмээдэг. 1945 оны 8-р сард Японыг эсэргүүцэх дайн ялалт олсноос тус хуурмаг засаг (тоглоомын улс) арилсан байна.

7. "Монголын хязгаарын засаг": Шилийн голын чуулганы дэд дарга бөгөөд Сөнөд баруун хошууны засагчин ван Дэмчигдонров 1936 оны 2-р сард Японы цэргийн талын дэмжлэгээр Сөнөд баруун хошуунд монгол цэргийн ерөнхий хороог байгуулж, тус жилийн 5-р сард монгол цэргийн засгийн ордныг Хөххотод жинхэнээр байгуулж, Шилийн гол, Цахар, Улаан Цав, Баян тал, Их Зуу зэрэг таван чуулган болон Бугат, Хөххот хоёр хотыг харьяалахаар тогтжээ. 1937 оны 11-р сард Японы цэргийн талынхан Чуулалт хаалгад Монголын хязгаарын холбоот зөвлөлийн хурлыг байгуулж, 1939 оны 9-р сард энэхүү Монголын хязгаарын холбоот зөвлөлийн хурлын суурин дээр Монголын чуулганыг холбож, өөртөө засах засгийн ордон, Цахарын өмнөд хэсгийн өөртөө засах засгийн ордон, Шаньсигийн умард хэсгийн өөртөө засах засгийн ордон зэрэг гурван

засгийн ордныг нийлүүлэн, Чуулалт хаалгад Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн ордныг байгуулж, Дэмчигдонровыг засгийн ордны тэргүүлэгчээр томилж, Чингис хааны он тооллыг хэрэглэжээ. Үүнийг Дундад улсын түүхэнд "Монголын хязгаарын засаг" гэдэг.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. "Монгол үгийн бодрол", 1908-1910 он (1-7, 9-23, 25 дугаар)
2. "Монголын сонин бичиг", 1909 он (3-13, 20 дугаар)
3. "Сонин бичиг", 1912 оны 8-р сарын 28 (17 дугаар)
4. "Ихдээ нийтлэх монгол бичгийн сэтгүүл", 1912 он (1-12, 17-21 дугаар)
5. "Монгол ер үгийн сэтгүүл", 1913-1914 он (1-18 дугаар)
6. "Шо Фан-гийн өдрийн сэтгүүл", 1919-1920 он (1, 19-63 дугаар)
7. "Мүгдэний монгол сэтгүүл", 1918 он (5-7, 56-63 дугаар)

8. "Дотоод Монголын ардын сэтгүүл", 1925 он (1-8 дугаар)

9. "Монгол, Төвдийн 7 өдрийн сэтгүүл", 1930 он (1-81 дугаар)

10. "Монгол, Төвдийн 10 өдрийн сэтгүүл", 1931-1933 он (1-8 дугаар)

11. "Монголын арван өдрийн дармал", 1930-1931 он (1-50 дугаар)

12. "Алаша хошууны дөхөм сэтгүүл", 1945-1949 он (1-294 дугаар)

Резюме

Настоящая статья посвящена проблеме возникновения, развития и становления газет и журналов, выпускаемых на монгольском языке. Начиная с 1905 года, когда чжун-ван Гунсэнноров Харчинский выпустил в своём хошуне "Гаригийн албан сэтгүүл" ("Официальный вестник дня") и "Нялх сэтгүүл" ("Младой журнал"), до сентября 1949 года на территории Китая появились в свет всего 131 газет и журналов на монгольском языке, из которых до наших дней дошли лишь 87. Автор подробно останавливается на анализе публикаций этих изданий.